



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 10 өдөр

Дугаар A/265

Булган

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох  
тухай

Монгол улсын Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 /а/, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүн ам, бэлчээрийн усан хангамжид зориулж, шинээр гүний худаг гаргах ажлын 1 дүгээр багцад шалгарсан "БИММ" ХХК-тай 95 147 182 /ерэн таван сая нэг зуун дөчин долоон мянга нэг зуун наян хоёр/, 2 дугаар багцад шалгарсан "Булган ус" ХХК-тай 92 000 000 /ерэн хоёр сая/ төгрөгөөр гүйцэтгүүлэх гэрээ байгуулах эрхийг тус тус олгосугай.

2. Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Ч.Амгалан/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү ажлын санхүүжилтийг холбогдох хууль, журмын дагуу 2019 оны Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний сангаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /С.Цэдэнлхам/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  З.БАТЗОРИГ



20190291